



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ОЛОН УЛС СУДЛАЛЫН  
ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261885 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Ч.Дашдаваа  
Утас: 261628 Цахим хаяг: [dashdavaach@audit.gov.mn](mailto:dashdavaach@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
Эйч Эл Би Монголиа Аудит ХХК  
Захирал: Ч.Энхтуяа  
Цахим хаяг: [enkhtuya@hlb.mn](mailto:enkhtuya@hlb.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл .....	15
3.6.3 Нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ОЛОН УЛС СУДЛАЛЫН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.ЗОЛБОО ТАНАА

2022.02.23 № 07/239  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2022\0223 Auditin 2 Gazar-1.Docx

701050146

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,791,030.17	78,836,926.50
33	Авлага		230,300.00
35	Бараа материал	73,791,030.17	78,606,626.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,447,816.38	54,564,634.27
392	Биет хөрөнгө	62,247,295.59	54,432,863.52
39201	Барилга, байгууламж	366,740.00	366,740.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(183,370.08)	(275,055.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	66,880,354.00	65,174,729.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,389,014.93)	(26,191,873.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,510,230.00	11,656,730.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,585,646.30)	(7,937,955.02)
39217	Номын фонд	10,648,002.90	11,639,547.90
393	Биет бус хөрөнгө	200,520.79	131,770.75
39301	Програм хангамж	1,045,000.00	1,045,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(844,479.21)	(913,229.25)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	136,238,846.55	133,401,560.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	136,238,846.55	133,401,560.77
51	Засгийн газрын хувь оролцоо	136,238,846.55	133,401,560.77
511	Засгийн газрын оруулсан капитал	60,364,169.48	60,364,169.48
512	Хуримтлагдсан үр дүн	75,366,385.37	72,670,651.29
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,358,357.20)	75,507,937.07
51220	Тайлант үеийн үр дүн	80,724,742.57	(2,837,285.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	508,291.70	366,740.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	136,238,846.55	133,401,560.77

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	840,872,270.00	819,857,925.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,443,170.00	12,320,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,443,170.00	12,320,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	45,443,170.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		123,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		12,196,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,551,600.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	13,891,570.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,429,100.00	807,537,925.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	777,916,300.00	747,305,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	777,916,300.00	747,305,200.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,512,800.00	60,232,725.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	16,810,000.00	59,330,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	702,800.00	902,725.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	760,147,527.43	822,695,210.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,147,527.43	822,695,210.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	712,270,542.04	753,166,050.84
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	584,876,278.00	563,609,338.00
210101	Цалин	584,876,278.00	563,609,338.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,290,280.00	73,346,511.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,368,973.00	51,619,970.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,935,812.00	5,778,273.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,646,668.00	4,526,394.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,121,710.00	1,038,352.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,217,117.00	10,383,522.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,239,749.61	18,166,901.73
210401	Бичиг хэргийн материал	415,055.00	1,710,967.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,288,116.61	1,212,205.06
210404	Ном, хэвлэлийн зардал	6,213,354.00	14,136,623.67
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,323,224.00	1,107,106.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	470,190.00
210601	Багаж хэрэгсэл	-	470,190.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	19,900,203.53	71,493,724.00

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,400,203.53	69,993,724.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,964,030.90	26,079,386.11
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	6,183,970.00	10,044,859.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,780,060.90	16,034,527.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,876,985.39	69,529,159.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	700,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,176,985.39	69,529,159.94
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,125,185.39	68,638,254.94
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	51,800.00	890,905.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	80,724,742.57	(2,837,285.78)
VI	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	80,724,742.57	(2,837,285.78)

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,364,169.48	508,291.70	(5,358,357.20)	55,514,103.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн		-	80,724,742.57	80,724,742.57
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,364,169.48	508,291.70	75,366,385.37	136,238,846.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	141,551.70	141,551.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(141,551.70)		(141,551.70)
Тайлант үеийн үр дүн	-	-	(2,837,285.78)	(2,837,285.78)
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	60,364,169.48	366,740.00	72,670,651.29	133,401,560.77



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	795,429,100.00	807,537,925.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	795,429,100.00	807,537,925.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	777,916,300.00	747,305,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	777,916,300.00	747,305,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,512,800.00	60,232,725.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,810,000.00	59,330,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	702,800.00	902,725.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	759,020,970.00	799,509,780.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,020,970.00	799,509,780.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,143,984.61	729,980,620.06
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	584,876,278.00	563,609,338.00
210101	Үндсэн цалин	398,040,305.00	424,760,340.00
210102	Нэмэгдэл	149,705,197.00	99,016,088.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,130,776.00	39,832,910.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	73,290,280.00	73,576,811.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	50,368,973.00	51,689,409.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	5,935,812.00	5,796,513.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	4,646,668.00	4,541,216.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,121,710.00	1,049,969.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	11,217,117.00	10,499,704.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,173,516.61	23,025,004.06
210401	Бичиг хэрэг	931,495.00	1,447,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,090,916.61	949,005.06
210404	Ном, хэвлэл	22,387,930.00	19,468,316.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	763,175.00	1,160,483.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,623,800.00	470,190.00
210601	Багаж техник хэрэгсэл	623,800.00	470,190.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,856,140.00	58,446,317.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	13,356,140.00	56,946,317.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,323,970.00	10,852,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,323,970.00	10,852,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,876,985.39	69,529,159.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	700,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	700,000.00	-

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	47,176,985.39	69,529,159.94
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,125,185.39	68,638,254.94
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	51,800.00	890,905.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,408,130.00	8,028,145.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	36,408,130.00	8,028,145.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,408,130.00	8,028,145.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,408,130.00	8,028,145.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(36,408,130.00)	(8,028,145.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	747,305,200.00	678,666,945.06	68,638,254.94
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	747,305,200.00	678,666,945.06	68,638,254.94
210	Бараа, үйлчилгээний зардал	746,698,400.00	678,666,945.06	68,031,454.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	615,772,500.00	563,609,338.00	52,163,162.00
210101	Үндсэн цалин	405,759,300.00	424,760,340.00	(19,001,040.00)
210102	Нэмэгдэл	151,501,200.00	99,016,088.00	52,485,112.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	58,512,000.00	39,832,910.00	18,679,090.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,129,300.00	73,576,811.00	9,552,489.00
210201	Тэтгэврийн даатгал	58,498,400.00	51,689,409.00	6,808,991.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,157,700.00	5,796,513.00	361,187.00
210203	ҮОМШӨ ний даатгал	4,926,200.00	4,541,216.00	384,984.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,231,500.00	1,049,969.00	181,531.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,315,500.00	10,499,704.00	1,815,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,429,900.00	23,365,224.06	1,064,675.94
210401	Бичиг хэрэг	816,200.00	1,447,200.00	(631,000.00)
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	945,200.00	949,005.06	(3,805.06)
210404	Ном, хэвлэл	22,000,000.00	19,808,536.00	2,191,464.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	668,500.00	1,160,483.00	(491,983.00)
2106	Эд хогшил худалдан авах	9,800,000.00	4,999,990.00	4,800,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,999,990.00	10.00
210604	Урсгал засвар	4,800,000.00	-	4,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,263,900.00	2,262,622.00	1,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	763,900.00	762,622.00	1,278.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,302,800.00	10,852,960.00	449,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,302,800.00	10,852,960.00	449,840.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	606,800.00	-	606,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	606,800.00	-	606,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	606,800.00	-	606,800.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	747,305,200.00	678,666,945.06	68,638,254.94
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	747,305,200.00	678,666,945.06	68,638,254.94
310001	Улсын төсвөөс санхүүжих	747,305,200.00	678,666,945.06	68,638,254.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	37	37	-

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
620001	Удирдах ажилтан	1	1	-
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	-
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	60,232,725.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	60,232,725.00
210	Бараа, үйлчилгээний зардал	-	59,341,820.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	59,341,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	59,341,820.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	890,905.00
213101	Засгийн газар хоорондын шилжүүлэг	-	890,905.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	60,232,725.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	60,232,725.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	59,330,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	902,725.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг дутуу тооцоолсонтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Ж.Гажидмаа, аудитор П.Ганчимэг, Ө.Батчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Ариундалай, захирал Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Эрхэм зорилго” нь Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгийг улс төр дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх гадаад таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах талаар суурь судалгаа явуулахад оршино.

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн нь Монгол улсын гадаад бодлого, орон судлалын суурь судалгаа хийх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлэх зорилготой. Монгол улсын хөрш, орон, гуравдагч хөрш орнууд, бүс нутаг олон талт хамтын ажиллагааны механизм, олон улсын байгууллагуудын судалгааг дагнан хариуцах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн;
- Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” 190 дугаар тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын сайдын 2017 оны 02 дугаар сарын 07-ны А/40 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагч болох Шинжлэх ухааны академиас жил бүр дотоод хяналт хийдэг боловч тайлант онд хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-т заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 760,147.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,601.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн үе шатны ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатны үед дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,837.3 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурч, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	230.3	230.3
Бараа материал	73,791.0	78,606.6	4,815.6
Үндсэн хөрөнгө	62,447.8	54,564.6	(7,883.2)
Нийт хөрөнгө	136,238.8	133,401.5	(2,837.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	136,238.8	133,401.5	(2,837.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	136,238.8	133,401.5	(2,837.3)

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл нь 230.3 мянган төгрөг байгаа нь НДШ-ийн авлага;

- Бараа материалын дансны үлдэгдэл 4,815.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын материал ном 3,123.6 мянган төгрөгөөр, бичиг хэргийн материал 1,692.0 мянган төгрөгөөр өссөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,883.2 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж болон ном 8,151.3 мянган төгрөгөөр худалдан авч ТӨБЗГ-ын 2021 оны 9 дүгээр сарын 8-ны А-2/1421 тоот тогтоолоор элэгдлээрээ өртгөө нөхсөн 3,853.5 мянган төгрөгийн тавилга, 8,865.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж (компьютер) актлан нийт хөрөнгө 4,567.6 мянган төгрөгөөр, хуримтлагдсан элэгдэл 3,315.6 мянган төгрөгөөр тус тус буурсан.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 874,917.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 869,865.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт төсвийг 122,560.5 мянган төгрөгөөр бууруулж 747,305.2 мянган төгрөгөөр баталж, төсвийг дахин тодотгоогүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд 747,305.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 747,305.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 678,667.0 мянган төгрөгийг зарцуулж 68,638.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 678,667.0 мянган төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь цалин, нэмэгдэл, НДШ-ийн зардлыг 61,715.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,064.6 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 4,800.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	747,305.2	678,667.0	68,638.2	90.8
1.1	80801	Үндсэн үйл ажиллагаа	746,698.4	678,667.0	68,031.4	90.8
1.2	80802	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	606.8	-	606.8	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд суурь судалгааны 3 төсөл, хамтарсан 2 төсөл, 2 грант төслийн санхүүжилтийн нийт 59,341.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 23,983.9 мянган, татвар, шимтгэлд 5,290.7 мянган, Компьютер дагалдах хэрэгсэлд 2,630.0 мянган, хэвлэлтийн зардалд 11,958.0 мянган, бичиг хэргийн зардалд 2,450.1 мянган, номын зардалд 11,641.1 мянган, томилолтын зардалд 1,080.0 мянган, хяналтын зардалд 308.0 мянган нийт 59,341.8 мянган төгрөгийг зарцуулж, 890.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Шинжлэх ухааны академийн Олон улсын харилцааны хүрээлэн” нэрийг тайлант онд “Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн” болгож өөрчилсөн.

Үүнтэй уялдуулан хүрээлэнгийн захирлын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 48 тоот тушаалаар Бүс нутаг, олон улсын байгууллагын салбарыг Бүс нутаг, олон талт хамтын ажиллагаа судлалын салбар, Захиргаа, аж ахуйн албыг Захиргаа, менежментийн алба болгон бүтцийг шинэчлэн баталсан.

Тайлант онд тус хүрээлэнгийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн, 3 арга хэмжээний хэрэгжилт 94.4 хувь, хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.8 хувийн биелэлттэй 3.6 хувиар зөрүүтэй буюу төсвийг хэмнэлттэй зарцуулж байгууллагын хүрэх үр дүнд хүрч ажилласан байна.

*Хүснэгт 3. Хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт*

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
24.6	Шинжлэх ухаан, технологи					
1	24.6.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зардлын эзлэх хувь	6.50	6.10	(0.40)	93.8
2	24.6.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	15.00	15.00	-	100.0
3	24.6.3	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	220.00	197.00	(23.00)	89.5
	<b>Дундаж хувь</b>					<b>94.4</b>

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татсан асуудал байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Нэмэлт төсвөөс санхүүжүүлсэн судалгааны ажлуудаас 2 сэдэвт ажил, 1 хамтарсан төсөл нь 2022 он дуустал хэрэгжихээр байгаа бөгөөд гүйцэтгэлийн тайлангаар 59,330.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй 89.9 хувийн үр дүнтэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн нь нийт 1,023,873.9 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 605,790.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь байршуулж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 241.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлснээс 241.5 мянган төгрөгийн 3 алдааг залруулж ажилласан байна.

Хүснэгт 4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	7,161.0	1	7,018.0	1	143.0	98.0
Зөвлөмж	2	6,099.7	2	6,099.7	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>13,260.7</b>	<b>3</b>	<b>13,117.7</b>	<b>1</b>	<b>143.0</b>	<b>99.0-</b>

ТҮШУ-5-3-ийн зэрэглэлд хамаарах цалинг шинэчлэн тогтоох, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж, Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроон байршуулж зөрчлийг давтан гаргасан байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 2,938.4 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс, 2,906.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 32.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулаагүй алдаа, зөрчил 32.0 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс 5,289.0 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

#### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг 1,849.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Нэр бүхий ажилчдын амралтын цалинг 145.1 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон;
- Нэр бүхий ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 62.0 мянган төгрөгөөр дутуу тооцсон;
- Цахим төлбөрийн баримтын 850.2 мянган төгрөгийн и-баримтын иж бүрдэл дутуу.

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. ХХОАТ-ын тайлагнахтай холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

ХХОАТ-н хөнгөлөлтийг тооцохдоо 42.0 мянган төгрөгөөр илүү, 74.0 мянган төгрөгөөр дутуу тооцож нийт 32.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон байна. Энэ нь үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д "23.1 Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **1.2. Өгсөн зөвлөмж:**

ХХОАТ-н хөнгөлөлтийн тооцооллыг жилийн эцэст холбогдох хуулийн албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээнд албан татварын хөнгөлөлтийн хэмжээг ногдуулан тооцоолж зөрүүгээр тохируулах бичилт хийж зөрүүг тооцож байх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
					о				о	н	о	дүн	о	дүн	о	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал																
1	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	Үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг 1,849.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна	СҮДТ-н эхний үлдэгдлийг залруулсан	1	1,849.1	1	1,849.1								
2	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	Нэр бүхий ажилчдын амралтын цалинг 145.1 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон	СҮДТ-н цалингийн зардлыг залруулсан	1	145.1	1	145.1								
3	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	Нэр бүхий ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг 62.0 мянган төгрөгөөр дутуу тооцсон	СҮДТ-н НДШ-н зардлыг залруулсан	1	62.0	1	62.0								
4	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	Цахим төлбөрийн баримтын 850.2 мянган төгрөгийн и-баримтын иж бүрдэл дутуу	Цахим төлбөрийн баримтыг нөхөн авч залруулсан	1	850.2	1	850.2								
5	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	ХХОАТ-н хөнгөлөлтийг тооцоходоо 42.0 мянган төгрөгөөр илүү, 74.0 мянган төгрөгөөр дутуу тооцож нийт 32.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон байна.	ХХОАТ-н хөнгөлөлтийн тооцооллыг холбогдох хуулийн дагуу зөв тооцоолох	1	32.0									1	32.0
Дүн					5	2,938.4	4	2,906.4	-	-	-	-	-	-	1	32.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
6	ОУСХ	АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ	Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэн нь нийт 1,023,873.9 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 605,790.7 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох	1	605,790.7					1	605,790.7	1	605,790.7		
Дүн					1	605,790.7							1	605,790.7		
Нийт дүн					6	608,729.1	4	2,906.4	-	-	1	605,790.7	1	605,790.7	1	32.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 109/А0150058  
АХГ-2022/50/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дүгээр зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 1,023,873,934.83 төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 605,790,678.67 төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад харцу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 дахь заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Нягтлан бодогч ажилтай Бямбаа овогтой Ганчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг гүйцэтгэх захирал Д.Золбоод даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ  
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ж.ГАЖИДМАА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264211

\\10.10.10.20\Bichig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-105.Docx

0010800362